



**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНС НЭВТРҮҮЛЭХ ТАЛААР АВАХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 43

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль болон "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл"-ийн зарим заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авахыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай:

1/тэтгэврийн даатгалд даатгагдсан 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн Монгол Улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харьяалалгүй хүнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх, эхний үлдэгдэл, шимтгэлийг уг дансанд тооцох, нийт даатгуулагчид мэдээлэх ажлыг 2000 оны эхний хагаст багтаан дуусгах;

2/холбогдох байгууллагаас баталж мөрдүүлэх журам, эрхийн актыг 1999 оны 10 дугаар сард багтаан батлан гаргах;

3/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс нээх үйл ажиллагааг удирдан зохицуулах, эрхлэн гүйцэтгэхэд чиглүүлж 1999 онд багтаан шинэчлэн зохион байгуулах.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ